



## НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 473

Улаанбаатар хот

Г Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн  
байдлаар шилжсэнтэй холбогдуулан хатуу хөл хорионы үед ажиллах зохион  
байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 39 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 23 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1320 дугаар захиралмийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст /Ковид-19/ цар тахлын шинэ голомт үүссэнтэй холбогдуулан хариу арга хэмжээг эрчимжүүлэх, халдварт, тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор дахин хатуу хөл хорионы дэглэм тогтоосон 14 хоногийн хугацаанд /2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийг хүртэл/ зайнаас ажиллах боломжгүй жирэмсэн болон 0-12 наасны хүүхэдтэй үйлчилгээний ажилтнуудад цалинтай чөлөө олгох нэrsийг 1 дүгээр хавсралтаар, зайнаас /онлайн горимоор/ ажиллах захиргааны албан хаагчдын нэrsийг 2 дугаар хавсралтаар, байр ашиглалтын албаны ажилтны хуваарийг 3 дугаар, цэвэрлэгээ үйлчилгээний ажилчдын хуваарийг 4 дүгээр, зоогийн газрын ажилчдын хуваарийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хуваарийг газрын ажилтан, албан хаагчдад танилцуулж, мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Ч.Шинэчимэг/-т үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдад хяналт тавьж үйлчилгээний ажилтнуудын ажил үүргийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг хэлтэс, албадын дарга, байр хариуцсан менежерүүдэд, цалин хөлсийг нь ажилласанд тооцон олгохыг ерөнхий нягтлан бодогч /Х.Цогзолмаа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Зайнаас /онлайн горимоор/ ажиллах захиргааны албан хаагчдын ажлын зохицуулалтыг "Зайнаас ажиллах түр журам"-г мөрдлөг болгон ажиллуулж, удирдлага чиг үүргээр ханган, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Ч.Однасан, Б.Галмандах/ нар, Захиргаа, санхүүгийн хэлтэс /Ч.Шинэчимэг/-т даалгасугай.

5. Дээрх зохицуулалтад хамрагдаж байгаа ажилтнуудад утсан харилцаа холбооны бэлэн байдлыг хангаж гар утсаа 24 цагаар нээлттэй байлгах, шаардлагатай цаг үед дудагдан ажиллахыг анхааруулсугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр ханган ажиллахыг Орлогч дарга /Ч.Однасан, Б.Галмандах/, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/ нар тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150500146